

“Монголын төмөр зам” ТӨХК

**2017 оны I улирлын худалдан авалтын  
үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитын тайлан**

2017 оны 4 сарын 15

## АГУУЛГА

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, үүрэг хариуцлага

- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэл
- Худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилт
- Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж

### Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй, үүрэг хариуцлага

#### 1. Нийтлэг үндэслэл

Төсвийн тухай хуулийн 12.1.16 ба 69.1 дэх заалт, Төрийн хяналт шалгалтын хуулийн 7.4 дэх заалт, Компанийн тухай хуулийн 94.5 дахь заалтыг үндэслэн дотоод аудитыг явуулна.

#### 2. Дотоод аудитын зорилго

Компанийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэл, 1 дүгээр улиралд хийгдсэн худалдан авалтын үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулсан эсэх, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шалгах

#### 3. Хэрэгжүүлэх хугацаа

Дотоод аудитыг 2017 оны 4 сарын 12-аас эхлэн ажлын 5 хоногт хийж гүйцэтгэнэ.

#### 4. Хамрах хүрээ

Хөрөнгө оруулалт, худалдан авалтын үйл ажиллагаа

Дараах ажлын горимуудыг ашиглан явуулна.

1. 1-3 сарын худалдан авалтын тайланг худалдан авалтын мэргэжилтнээр гаргуулан авах
2. 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэлийг үзэх

3. Худалдан авалтыг хөрөнгө оруулалтын төлөвлөгөө болон мөнгөн хөрөнгийн дансны гүйлгээтэй тулгаж үзэх
4. Мөнгөн хөрөнгийн дансуудаас худалдан авалтын гүйлгээний анхан шатны баримт бүрдүүлэлтийг шалгах
5. Худалдан авалтад дүрэм журмын нийцэлд аудит хийх
6. Тайлан бичих

## **5. Үүрэг хариуцлага**

Дотоод аудитад хамрагдаж буй байгууллага:

- Шаардлагатай мэдээлэл, материал, санхүүгийн баримт материалыг аудитын ажилтанд шаардсан хугацаанд саадгүй гаргаж өгөх
- Дотоод аудитын тайлангийн төсөлтэй танилцаж, санал, тайлбар өгөх
- Аудитын ажилтаны гаргасан шийдвэр, зөвлөмжийг хэрэгжүүлэх

:Дотоод аудитын ажлын хэсэг

- Дотоод аудитад хамрагдаж буй объектод хүндрэл учруулахгүй байх
- Дотоод аудитын ажлын явцад хамрагдаж буй хэлтэс, ажилтаны талаарх мэдээллийн нууцлалыг хадгалах
- Дотоод аудитын тайлангийн төслийг тухайн объектдын холбогдох албан тушаалтанд танилцуулах, шаардлагатай гэж үзвэл залруулга хийх
- Дотоод аудитын дүрмийг баримтлан, бие даасан байдалтай гүйцэтгэх
- Дотоод аудитын тайлангаас гарсан шийдвэр, зөвлөмжийг холбогдох хэлтэс, газруудад хүргүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих.

## **6. Дотоод аудитын дүнг тайлагнах**

Дотоод аудитын тайлан, зөвлөмжийг удирдлага, хариуцсан хэлтсийн дарга болон ажилтанд танилцуулсан байна.

---

## Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний үндэслэл

Худалдан авалтын 2017 оны төлөвлөлтийг 2016 оны төлөвлөгөөтэй нэр төрлөөр харьцуулан үзэхэд дараах байдалтай байна.

мян.төг

№	Бараа, ажил үйлчилгээний нэр төрөл	2016 оны төлөвлөгөө	2017 оны төлөвлөгөө	Хувь
<i>Хөрөнгө оруулалтын шинж чанартай</i>				
<b>Төв оффисын үйл ажиллагаанд</b>				
	Тавилга, эд хогшил	40,630	2,250	5.5%
	Компьютер, техник хэрэгсэл	80,150	3,383	4.2%
	Програм хангамж	6,000	1,800	30%
	Тоног төхөөрөмж	45,780	1,800	3.9%
	Багаж, техник хэрэгсэл	44,850		
	Ном тохимол, эмхтгэл	2,238.9		
	НБББББ	9,500		
	Зурвас газрын үнэлгээ	246,000		
	<b>Дүн</b>	<b>475,148.9</b>	<b>9,233</b>	<b>1.9%</b>
<b>Төмөртэй өртөөний үйл ажиллагаанд</b>				
	Тавилга, эд хогшил		650	
	Компьютер, техник хэрэгсэл		2,270	
	Зүтгүүрийн депод		303,190	
	Орон сууц кемп		249,000	
	<b>Дүн</b>		<b>555,110</b>	
	<b>Зардлын шинж чанартай худалдан авалт</b>	<b>2,128,016</b>	<b>2,604,989</b>	
	<b>Нийт дүн</b>	<b>2,603,164.9</b>	<b>3,169,332</b>	<b>121.7%</b>

**Тайлбар:** Энэ онд хийгдэх худалдан авалтын төвлөрөл Төмөртэй өртөөнд чиглэсэн байна. Өртөөнд хийгдэх орон сууц, кемп, зүтгүүрт хэрэгтэй тоног төхөөрөмжүүд болон илчит тэрэг вагоны сэлбэг хэрэгслүүдэд гол хөрөнгө зарцуулагдахаар байна.

Төв оффисын үйл ажиллагаанд зориулагдсан худалдан авалтыг эрс багасгасан нь төсвийн хэмнэлтэд чухал нөлөө үзүүлэх юм. Төлөвлөгөөнд орсон бараа ажил үйлчилгээг задалж үзвэл цахим баримт хадгалах шүүгээ, оффисын хяналтын камер болон вирусын програм, хивс угаагч машин зэргээс бүрдсэн байна.

Компанийн 2017 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэлтэй, хэмнэлттэй байхаар төлөвлөсөн гэж үзэж байна.

## Худалдан авах ажиллагааны журмын хэрэгжилт

Тайлант хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д

Нээлттэй тендер шалгаруулалт-1



Шууд худалдан авалтаар-18 худалдан авалтууд хийгдсэн байна.

Үүнд:

Шууд худалдан авалтууд нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 8.1.1 д заасан босго үнийн дээд хязгаарыг зөрчөөгүй байна.

мян.төг

№	Бараа, ажил, үйлчилгээ, тоо хэмжээ	Гэрээний дүн	Гүйцэтгэл	Нийлүүлэгч	Хөнгөлөлт	Журам	Төлөвлөгөөнд тусгагдсан эсэх	Тайлбар
1	СКД 4Б, MR 3002 зүтгүүрийн сэлбэг хэрэгсэл-8ш	11,668,690	11,668,690	“Дэгжих есөнган” ХХК	-	ХА	ЗШЧХА -Тоног төхөөрмжийн зардал	Зүтгүүрийн тасралтгүй үйл ажиллагаанд.
2	Зүтгүүрийн хөргөлтийн сэнсний 3 фазын хувьсах гүйдлийн цахилгаан хөдөлгүүрийг засварласан	5,938,231	5,641,319	“Гэт Женероус” ХХК	-	ШХА		
3	Разетка		52,500	Хувь хүн	-	ШХА	ЗШЧХА Аж ахуй эд, материал	Төмөртэй өртөөний албан хэрэгцээнд.
4	Залгуур		37,500					
5	Шүрүүп		5,000					
6	Шалны мод		40,000					
7	Дотор хогын шүүр		45,000					
8	Уртасгагч		60,000					
9	Ажлын цагаан бээлий		21,500					
10	Бородок		15,000					
11	Гидро шингэн		58,000					
12	Гэрлийн чийдэн		82,500					
13	Модны харуул		30,000					

14	Тескитэй ширээ-2ш		1,260,000	Хувь хүн	-	ШХА	ЗШЧХА -Тоног төхөөрм жийн зардал	Төмөртэй өртөөний албан хэрэгцээнд.
15	Гагхуурын хувцас болон бээлий		217,800	Hermes худалдааны төв	-	ШХА		
16	P-50 зам төмрийн хавчуулга		150,000	Хувь хүн	-	ШХА		
17	Элс		676,029	Дархан татах хэсэг	-	ШХА		
18	USB карт уншигч		573,176	-	-	ШХА		Албан хэрэгцээнд
19	Сэлбэг хэрэгсэл		1,973,800	Big Худалдааны төв	-	ШХА	ЗШЧХА- Аж ахуй эд, материал ЗШЧХА- Тоног төхөөрм жийн зардал	Төмөртэй өртөө болон Дохиолол холбооны сэлбэг хэрэгсэл.
20	Эд анги, сэлбэг хэрэгсэл		216,000					
21	Evolution зүтгүүрийн шүүлтүүрийн элементүүд	40,762,700	28,533,890	“Альфа Филтер” ХХК	-	ХА		Гэрээний үнийн 70%, зүтгүүрийн тасралтгүй үйл ажиллгаанд.
22	Хяналтын камер-26ш, бичигч-7ш, хард диск-7ш, кабель-450м, тэжээлийн кабель-450м	4,966,500	4,966,500	“Ай Ти Молл” ХКК	-	ХА		Албан хэрэгцээнд.
23	Хяналтын бичигч дэлгэч - 12 инч-7ш, хувиргагч-7ш	2,618,000	2,618,000	“Эн Эс Ти Юу” ХХК	-	ХА		
24	Балтай тос		500,000	Хувь хүн	-	ШХА		
25	Кофе чанагчын сэлбэг хэрэгсэл		98,000	“БСБ Электроникс” ХХК	-	ШХА	ЗШЧХА- Аж ахуй эд, материал	Philips кофе чанагч нь ашиглагтын явцад бутлагч 2, 3 араанд чулуу орж хагарсан.
26	Хивс, хивсэнцэр шал угаагч автомат машин		759,000	“Смарт Электроникс” ХХК	-	ХА	ЗШЧХА -Аж ахуй эд, материал	Албан хэрэгцээнд.
27	Air 2 Ipad хавтас		58,000	TEDY худалдааны төв	-	ШХА	Тийм	Tablet компьютерийг компанийн удирдлага байнгын хорооны хурал болон ЗТХЯ-ны цаг үеийн шуурхай хурлууд дээр холбогдох хууль
28	Ipad Air 2 tablet computer		1,709,990	“Номин Трейдинг” ХХК	-	ХА	ЗШЧХА -Аж ахуй эд,	

							материал	тогтоомж дүрэм, журмуудыг татан авч ашиглахад.
29	Тоормосны шахавч		5,500,000	УБТЗ төв засварын үйлдвэр	-	ШХА		Зүтгүүрийн тасралтгүй үйл ажиллагаанд.
30	Тээвэрлэлт (УБ зүтгүүрийн депо-Төмөртэй өртөө)	825,000	825,000	Хувь хүн	-	ШХА	ЗШЧХА -Тоног төхөөрөмжийн зардал	
31	Ажил гүйцэтгэх гэрээ	690,000	759,000	“Лэндс” ХХК	-	ХА	ЗШЧХА - Кемпийн зардал	Хүнд даацын машин механизмуудад зах зээлийн хөрөнгийн үнэлгээ хийсэн.
32	Ажлын хувцас		63,000	“Их Уул Трейд” ХХК	-	ШХА	2017 ЗТ- Бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний хөлс	Үйлчилгээний ажилтнуудын хувцас элэгдсэн тул, шинээр 2ш захиалгаар хийлгэсэн.
33	Байгууллагын танилцуулга хэвлэлт.		436,363	“Вержувль артс” ХХК	-	ШХА	ЗШЧХА - Хөдөлмөр хамгаалал	Төрийн өмчийн менежмент ба нийгмийн хариуцлага 2017 нээлттэй өдөрлөгийн үйл ажиллагаанд ашиглагдах гарын авлагуудын хэвлэлт.
34	Брошур		150,000	“Мөнгөн ганзай” ХХК	-	ШХА	2017 ЗТ-Зар сурталчилгаа, маркетингийн зардал	
35	Сүлжээний төхөөрөмж суурилуулалт		1,412,000	“Мобинет” ХХК	-	ШХА		Албан хэрэгцээнд.



36	Оффисын тохижилт		250,000	-	-	ШХА	2017 ЗТ- Шуудан , холбоо интернэ т	
37	Харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх	178,720,000	-	-	-	НТШ	ЗШЧХА -кемп	2017.03.24-нд зарлагдсан. Хэрэгжих шатандаа явж байна.
<b>НИЙТ ДҮН</b>		<b>262,640,279</b>	<b>71,462,557</b>					


**Тайлбар:** 1. Нээлттэй тендер шалгаруулалтаар хийгдэх харуул хамгаалалтын үйлчилгээ үзүүлэх зардлын шинжтэй худалдан авалт нь одоогоор бүрэн эцэслээгүй. Тендер шалгаруулалтын процессын дараах үе шатууд хийгдэж байгаа. Үүнд:

- хараат бус 2 гишүүн оррлцсон 5 гишүүн бүхий үнэлгээний хороог Гүйцэтгэх захирлын тушаалаар байгуулсан,
- тендерийн урилга тараагдсан
- тендерийн материал хүлээн авалт хийгдэж байна.


2. Бусад худалдан авалтууд журмын дагуу хийгдсэн гэж дүгнэж байна.


### Нэгдсэн дүгнэлт, зөвлөмж

1. Тайлант үеийн худалдан авалтын тайланг касс, харилцахын тайлангийн холбогдох гүйлгээтэй тулгалт хийж, анхан шатны баримт бүрдүүлэлтийг шалгаж үзэхэд үнэн зөв, бүрэн гүйцэд байв.
2. Худалдан авалтын төлөвлөгөө хэмнэлттэй үндэслэлтэй төлөвлөгдсөн.
3. Худалдан авах ажиллагаанд мөрдөх журам хуулийн дагуу хэрэгжсэн.
4. Төлөвлөгөөт бус худалдан авалтууд албан хэрэгцээнд тулгуурлагдсан.
5. Хэмнэлтийн горимд нийцүүлэн төлөвлөгөөнд 2 ширхэгээр тусгагдсан хивс угаагч машин 1 ширхэгийг худалдан авсан зэрэг нь зөрчилгүй дүгнэлт болно.

Тайлан бэлтгэсэн: дотоод аудитын ажилтан  Д.Болормаа

Танилцсан: ЗУХ-ийн дарга  М.Гантөгс

Худалдан авалтын ажилтан  Б.Халиунаа

Худалдан авалтын ажилтан  Б.Ундрах